


## ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЧИГЛЭЛИЙН СУДАЛГАА, СУРГАЛТЫГ ДЭМЖИХ “ТИНК БАНК” ХӨТӨЛБӨР

### 1. Нийтлэг үндэслэл

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл баримт бичигт тусгагдсан хүний хөгжил, судалгаа, сургалтын зорилтууд нь эдийн засаг, санхүүгийн чиглэлээрх судалгаа, сургалтыг дэмжих “Тинк банк” хөтөлбөр (цаашид “Хөтөлбөр” гэх)-ийг боловсруулах нэг үндэслэл болно.

Бусад орны Төв банкны жишгийн дагуу Монголбанкнаас эдийн засаг, санхүүгийн чиглэлийн эрдэм шинжилгээ, сургалтыг дэмжих ажилд манлайлан оролцож, Төв банк болон эрдэм шинжилгээний байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэн, боловсон хүчний чадавхийг бэхжүүлэх, судалгааны чанарыг дээшлүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан “Олон улсын шаардлага хангасан дээд боловсролын сургалтын байгууллагын тоог нэмэгдүүлж, чанарыг дээшлүүлэн олон улсад эрэмбэлэгдсэн, хүлээн зөвшөөрөгдсөн хөтөлбөр бүхий үндэсний судалгааны их сургуультай болсон байна” гэсэн зорилт, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан “хөгжлийн тэргүүлэх чиглэл болон эрэлттэй мэргэжлээр суралцаж байгаа сургалт, судалгааны ажлын амжилтаар тэргүүлэгч оюутнуудад сургалтын төлбөрийн бүрэн тэтгэлэг олгоно” гэсэн зорилтууд нь Монголбанкнаас судалгаа, сургалтыг дэмжих зорилттой нийцтэй байна.



## **2. Хөтөлбөрийн зорилго**


2.1. Монголбанкны үндсэн зорилтын хүрээнд эдийн засаг, санхүүгийн чиглэлээр судалгаа шинжилгээ хийдэг судлаач, эрдэмтэд болон оюутнуудын эрдэм шинжилгээ, сургалтын чанарыг дээшлүүлэх, бодлого боловсруулан хэрэгжүүлэхэд оролцох оролцоог нь нэмэгдүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

## **3. Хөтөлбөрийн тэргүүлэх чиглэл, арга хэмжээ**

- 3.1. Магадлан итгэмжлэгдсэн их сургуулиудын тодорхой шалгуур хангасан тэнхимд эдийн засаг, санхүүгийн чиглэлээр судалгааны магистрын түвшинд суралцах оюутнуудад өрсөлдөөнт “Монголбанкны Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэг” олгох. Тэтгэлгийн хүрээнд оюутнуудыг сургалтын төлбөрөөс 100% чөлөөлж, сар бүр 800 мянган төгрөгийн тэтгэмж олгоно.
- 3.2. Их дээд сургуулиудыг эрдэмтэн, судлаачидтай эдийн засаг, санхүүгийн чиглэлээр хамтарсан судалгаа, эрдэм шинжилгээний ажил хийх,
- 3.3. Банк, санхүүгийн чиглэлээрх сургалт, семинарт их дээд сургуулиудын багш, судлаач нарыг оролцуулах,
- 3.4. Монголбанкны мэдээллийн цагийг их дээд сургуулиудтай хамтран зохион байгуулах,
- 3.5. Их, дээд сургуулиудын шаардлага хангасан оюутнуудыг практик дадлага хийх боломжоор хангах,
- 3.6. Судлаач, бодлого боловсруулагч нарын хамтарсан хэлэлцүүлгийг тогтмол зохион байгуулах,
- 3.7. Ахисан түвшний суралцагчдын судалгаа, сургалтыг чанаржуулахад дэмжлэг үзүүлэх,
- 3.8. Иргэдийн эдийн засаг, санхүүгийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн товхимол, гарын авлага гаргаж, сургалт хэлэлцүүлэг зохион байгуулах зэрэг тэргүүлэх чиглэл, арга хэмжээнд төвлөрч ажиллана.

## **4. Хөтөлбөрийн хэрэгжих хугацаа**

4.1. Хөтөлбөрийг 2021-2023 оны хооронд 3 жилийн хугацаатай хэрэгжүүлнэ.



## 5. Хөтөлбөрийн хүрээнд хүрэх үр дүн

Хөтөлбөр хэрэгжсэнээр дараах үр дүнд хүрнэ. Үүнд:

- 5.1. Эдийн засаг, санхүүгийн чиглэлээр ахисан ~~түвшний суралцагчдын~~ судалгааны ажлын чанар сайжирна,
- 5.2. Хөтөлбөрт оролцогч их, дээд сургуулиудын багш нарын судалгаа, эрдэм шинжилгээний ажлын чанар, практик ач холбогдлыг дээшлүүлнэ,
- 5.3. Судлаач нарын бүтээлийг олон нийтэд түгээх, бодлого боловсруулахад оролцох оролцоог нь нэмэгдүүлнэ.

## 6. Хөтөлбөрийн санхүүжилт

- 6.1. Хөтөлбөрийн хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээг Монголбанк санхүүжүүлэхээс гадна гадаадын төсөл хөтөлбөрийн санхүүжилт буюу хандив, тусламжаас санхүүжүүлж ажиллана.
- 6.2. Санхүүжилтийг ил тод, үр ашигтай зарцуулах зарчмыг баримтална.

## 7. Хөтөлбөрийн хэрэгжилтэд хийх хяналт, үнэлгээ

- 7.1. Монголбанкны Дотоод аудитын газар хөтөлбөрийн хэрэгжилтэд 3 жил тутам үнэлгээ хийж, санал зөвлөмжийг боловсруулан шаардлагатай бол хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулна.
- 7.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийсэн хяналт, үнэлгээний дүгнэлтэд үндэслэн хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу нэмэлт, өөрчлөлт оруулж болно.